



Б.Мөнхзаяа (Ph.D)  
2022.3.21



## СЭЗИС-ИЙН НЭРЭМЖИТ ОЮУТНЫ ПОСТЕР ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ 2021-2022 оны хичээлийн жил

ПЛАТИНУМ ИВЭЭН ТЭТГЭГЧ:



МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ:



2022.5.6



С байр 4 давхар



976 9909 9765



[munkhtsetseg.d@ufe.edu.mn](mailto:munkhtsetseg.d@ufe.edu.mn)



[https://ufe.edu.mn/Default.aspx?page=4069&news\\_id=30396](https://ufe.edu.mn/Default.aspx?page=4069&news_id=30396)

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



**ГУРВАН-ЭРДЭНЭ**  
БАГШИЙН ДЭЭД СУРГУУЛЬ



**ШИНЭ АНАГААХ УХААН ИХ СУРГУУЛЬ**  
ШИНЖЛЭХ УХААН – СУРГАЛТ – ҮЙЛДЭЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР

**Хурлын зорилго:** Онол, практикийн ач холбогдол бүхий судалгааны бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжих, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

**Хамрах хүрээ:** СЭЗИС-ийн оюутны эрдэм шинжилгээний XIV бага хуралд эрх зүй, нийгэм, эдийн засаг, бизнес, санхүү, мэдээллийн систем, гадаад хэлний чиглэлээр бакалаврын түвшинд суралцаж буй бүх оюутан суралцаж буй хэлбэрээс үл хамааран (өдрийн, бүтэн цагийн, шаталсан сургалттай, бямба гаргийн, оройн, цахим, алсын зайн эчнээ гэх мэт) оролцох боломжтой.

**Зохион байгуулалт:** Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

**Эхний шат:** Илтгэлийг 2022 оны 5-р сарын 2-ны 09:00 цагаас өмнө [munkhtsetseg.d@ufe.edu.mn](mailto:munkhtsetseg.d@ufe.edu.mn) электрон хэлбэрээр хүлээн авна. Электрон хэлбэрээр ирүүлсэн илтгэлүүдийг эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах комиссын гишүүд урьдчилан шүүж, хоёр дахь шатанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

**Хоёр дахь шат:** Хоёр дахь шатанд шалгарсан илтгэлүүдийг постер хэлбэрээр бэлтгэх зааврыг 2022 оны 5-р сарын 3-ны 18:00 цагаас өмнө илтгэгчид мэйлээр илгээнэ. Илтгэгч постероо зааврын дагуу хэвлүүлж, 2022 оны 5-р сарын 5-ны 18:00 цагаас өмнө СЭЗИС-ийн В байрны 2 давхарт бэлтгэсэн талбайд байрлуулсан байна.

**Хугацаа:** Шалгарсан илтгэгч 2022 оны 5-р сарын 6-ны өдрийн 10.00 цагт постерын хажууд олон нийтэд танилцуулгаа хийнэ. Эрдэм шинжилгээний хурлыг шүүх комиссын гишүүд мөн өдрийн 14.00 цагт постер илтгэлүүдтэй танилцана.

**Шагнал:**

1-р байр: Өргөмжлөл, 500'000 төгрөг

2-р байр: Өргөмжлөл, 400'000 төгрөг

СЭЗИС-ийн нэрэмжит оюутны постер илтгэлийн уралдаанд оролцсон нийт оролцогчдод “БАТЛАМЖ” гардуулж, сургуулийн цахим хуудсанд байршуулж, олон нийтийн хүртээл болгоно.



Б.Мөнхзаяа (Ph.D)  
2022.3.21



## СЭЗИС-ИЙН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ XIV БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

2021-2022 оны хичээлийн жил

### ПЛАТИНУМ ИВЭЭН ТЭТГЭГЧ:



### МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ:



2022.5.6



С байр 4 давхар



976 9909 9765



[munkhtsetseg.d@ufe.edu.mn](mailto:munkhtsetseg.d@ufe.edu.mn)



[https://ufe.edu.mn/Default.aspx?page=4069&news\\_id=30396](https://ufe.edu.mn/Default.aspx?page=4069&news_id=30396)

### ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



**ГУРВАН-ЭРДЭНЭ**  
БАГШИЙН ДЭЭД СУРГУУЛЬ



**ШИНЭ АНАГААХ УХААН ИХ СУРГУУЛЬ**  
ШИНЖЛЭХ УХААН – СУРГАЛТ – ҮЙЛДЭЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР

Санхүү эдийн засгийн их сургуулиас 14 жилийн турш уламжлал болгон зохион байгуулж ирсэн “Оюутны эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 2022 оны 5 сарын 2-6 өдрүүдэд эдийн засаг, эрх зүй, бизнесийн удирдлагын чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудын оюутнуудын дунд нээлттэй зохион байгуулах гэж байна.

**Хурлын зорилго:** Онол, практикийн ач холбогдол бүхий судалгааны бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхиүлэн дэмжихэд чиглэгдэнэ.

**Хамрах хүрээ:** СЭЗИС-ийн оюутны эрдэм шинжилгээний XIV бага хуралд эрх зүй, нийгэм, эдийн засаг, бизнес, санхүү, мэдээллийн систем, гадаад хэлний чиглэлээр бакалаврын түвшинд суралцаж буй бүх оюутан суралцаж буй хэлбэрээс үл хамааран (өдрийн, бүтэн цагийн, шаталсан сургалттай, бямба гаргийн, оройн, цахим, алсын зайн эчнээ гэх мэт) оролцох боломжтой.

**Зохион байгуулалт:** Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг дараах 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

**Эхний шат:** Илтгэлийг 2022 оны 5-р сарын 2-ны 09:00 цагаас өмнө электрон хэлбэрээр хүлээн авна. Электрон хэлбэрээр ирүүлсэн илтгэлүүдийг эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах комиссын гишүүд урьдчилан шүүж, хоёр дахь шатанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

**Хоёр дахь шат:** Илтгэлүүдийг нэгтгэсэн гурван салбараар хэлэлцэж, салбар бүрээс эхний гурван байрыг шалгаруулж, урамшуулна. Үүнд:

**Салбар 1:** “Эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн салбар хурал”-д дараах чиглэлийг багтаана.

- ✓ Эдийн засаг
- ✓ Санхүү
- ✓ Нягтлан бодох бүртгэл

**Салбар 2:** “Бизнес, менежментийн салбар хурал”-д дараах чиглэлийг багтаана. Үүнд:

- ✓ Бизнесийн удирдлага
- ✓ Маркетинг
- ✓ Энтрепренершип, инноваци
- ✓ Институц, цахим шилжилт
- ✓ Мэдээллийн системийн менежмент
- ✓ Аялал жуулчлалын менежмент
- ✓ Зочлохуйн үйлчилгээний менежмент

**Салбар 3:** “Хүмүүнлэг, нийгмийн салбар хурал”-д дараах чиглэлийг багтаана. Үүнд:

- ✓ Боловсролын удирдлага
- ✓ Хүмүүнлэг, нийгмийн ухаан
- ✓ Эрх зүй, нийтийн эрх ашгийн эрх ашиг
- ✓ Нийгмийн оролцоо, түншлэл
- ✓ Хэл шинжлэл

**Хугацаа:** Судалгааны ажлыг бүрэн эхээр 2022 оны 5-р сарын 2-ны 09:00 цагаас өмнө [munkhtsetseg.d@ufe.edu.mn](mailto:munkhtsetseg.d@ufe.edu.mn) хаягаар электрон хэлбэрээр хүлээн авна. Хоёр дахь шатанд шалгарсан оролцогчдод 2022 оны 5-р сарын 5-ны дотор мэйлээр мэдээлэл хүргэнэ. Шалгарсан оролцогчдын илтгэлийн танилцуулга (ppt, pdf гэх мэт) файлыг 2022 оны 5-р сарын 5-ны өдрийг дуустал [munkhtsetseg.d@ufe.edu.mn](mailto:munkhtsetseg.d@ufe.edu.mn) хаягаар хүлээж авна.

Шалгарсан шилдэг илтгэлүүдийн нэгдсэн хуралдааныг 2022 оны 5-р сарын 6-ны өдрийн 10.00 цагт СЭЗИС-ийн С байрны 4 давхарт зохион байгуулна.

**Судалгааны ажилд тавигдах ерөнхий шаардлага:**

“СЭЗИС-ийн оюутны эрдэм шинжилгээний XIV бага хурал”-д илтгэх судалгааны ажлын сэдэв нь СЭЗИС-ийн судалгааны дараах тэргүүлэх чиглэлд нийцсэн байх шаардлагатай. Үүнд:

- Эдийн засгийн уялдуулалт ба институцийн асуудлууд
- Институц, цахим шилжилт ба байгууллагын хөгжил
- Энтрепренершип ба бизнес, нийгмийн салбарт инновацийг бүтээх, нэвтрүүлэх, удирдах асуудлууд
- Боловсролын шинэ хандлага, удирдлага, чанар, үр ашиг
- Санхүүгийн салбар, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг үндэсний стратегийн салбаруудын хөгжлийн асуудлууд
- Нийгмийн хөгжил, түншлэл, оролцоо, нийтийн эрх ашгийн тулгамдсан асуудлууд
- Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал; хоёр ба гуравдагч хөрш орнуудын гео-эдийн засаг
- Эрх зүй ба эдийн засаг

Дараах ерөнхий шаардлагыг хангасан судалгааны ажлыг хүлээн авна. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй байх
- Шинэлэг санааг дэвшүүлсэн, эрэл хайгуул хийсэн байх
- Практик ач холбогдолтой байх

- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх

#### Бичвэрт тавигдах шаардлага:

1. Эрдэм шинжилгээний бүтээл нь дараах хэсгүүдтэй байна.
  - Бүтээлийн нэр
  - Зохиогчийн овог нэр, хаяг, электрон шуудангийн хаяг
  - Товч хураангуй
  - Түлхүүр үг
  - Оршил
  - Үндсэн хэсэг/судлагдсан байдал, судалгааны арга зүй, судалгааны үр дүн гэсэн дэд хэсгүүд эсвэл сэдвээс хамаарсан дэд сэдвүүд байж болно/
  - Дүгнэлт
  - Зөвлөмж
  - Ном зүйн жагсаалт
  - Хавсралт
2. Эрдэм шинжилгээний бүтээлд авсан эшлэлийн эх үүсвэрүүдийг бүтээл дотор болон ном зүйн жагсаалтад бичнэ. Үүнд: *СЭЗДС-ийн захирлын 2011 оны 9-р сарын 28-ны өдрийн 188 тушаалаар баталсан “Эшлэл авах, эх үүсвэрийг заах болон номзүйн бичилт хийх стандарт”-ыг мөрдөнө.*
3. Бүтээл нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмж, номзүйн жагсаалтыг оролцуулан А4 (210x297mm) хэмжээтэй 12 хүртэлх хуудсанд багтана.
4. Бүтээл нь Microsoft Office хэрэглээний программ дээр хийгдсэн, \*.doc, \*.pdf өргөтгөлтэй байна.
5. Бүтээлийн ерөнхий гарчиг нь 14pt хэмжээтэй **Bold**, ТОМ ҮСГЭЭР, Дэд гарчгууд нь 12pt үсгийн хэмжээтэй **Bold** форматтай, Бичвэрийн үсгийн фонт –[Times New Roman, 12pt, мөр хоорондын зай 1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна]
6. Цаасны хэмжээ (Page Setup->Margins): Top:2.5cm, Bottom:2cm, Left:3cm (үдэх зай багтсан), Right:2cm байна.
7. Бичвэр дунд мөр хооронд жагсаалтыг тэмдэглэхдээ (Paragraph->Bullets) цэгэн тэмдэг (•)-ийг сонгоно.
8. Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна. Илтгэлийн нэрэнд орсон үг түлхүүр үг болохгүй.
9. Математик, статистик томъёоллыг “Equation” ашиглан оруулах ба тэмдэгтийн хэмжээ 10pt, **Bold**, *Italic* байна.
10. Зураг, хүснэгт нь бүгд дугаартай, нэртэй байх ба дугаар нэр хоёр нь 10pt, **Bold** үсгийн хэмжээтэй хуудсын зүүн талд байрласан байна. Фото зураг \*.JPEG өргөтгөлтэй байна.
11. Үнэлгээ хийсэн тоон болон чанарын мэдээллийг хавсралтын жагсаалтад дугаарлан оруулна. Харин Estimation Output, Actual, Fitted, Residual Graph-ийг хавсралтын жагсаалтад дугаарлан оруулж, нэг нүүрэнд тусган үзүүлнэ.
12. **Номзүй** –[Times New Roman, 12pt, ALL CAPS, **Bold**, зүүн талаас зэрэгцсэн байна]
  - Номзүйн жагсаалт нь үндсэн бичвэртэй адил үсгийн фонт, хэмжээтэй байна.

- Мөр хоорондын зай [(Spacing: After Opt, Before Opt), (Line spacing: Multiple At 1.15sp)].
- Эх сурвалжуудыг дугаарлахгүй.
- Номзүйн жагсаалтад үсгийг тод (**Bold**)-оор бичихгүй.
- Зохиогчийн нэрийг мөрийн эхнээс бичиж, дараагийн мөрүүдийг догол мөрнөөс буюу зохиогчийн нэрийг харахад хялбар байдлаар бичнэ.

#### Хэл найруулгад тавигдах шаардлага:

- Учир шалтгааны (логик) нарийн дараалалтай, тодорхой, баталгаа нотолгоо сайтай байх
- Сэдэвт холбогдох өмнөх судалгааг бүрэн гүйцэд авч үзсэн байх
- Тогтсон, оновчтой нэр томъёо хэрэглэсэн байх
- Эшлэл, догол мөр авсан байх
- Ярианы хэлний үг хэллэг хэрэгдэхгүй байх
- Нэгдүгээр биеийн төлөөний үгийг олон тоогоор бичих
- Зөв бичих дүрмийн алдаагүй байх
- Цэг тэмдгийг оновчтой байдлаар хэрэглэсэн байх

#### Илтгэлийг шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд:

- Шинжлэх ухааны үндэслэл
- Шинэлэг санаа дэвшүүлсэн байдал
- Практик ач холбогдол
- Асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн байдал
- Судалгааны арга аргачлал
- Илтгэх болон хэлэлцэх ур чадвар

#### Шагнал:

Нэгдсэн хуралдааныг дээр дурдсан нэгтгэсэн 3 салбараар 2022 оны 5-р сарын 6-ны өдөр танхимаар зохион байгуулах бөгөөд видео бичлэг болон live хийж, олон нийтэд түгээнэ.

Нэгтгэсэн 3 салбараас тус бүр дараах байр эзлүүлнэ. Үүнд:

1-р байр: Өргөмжлөл, 500'000 төгрөг \* 3 салбар

2-р байр: Өргөмжлөл, 400'000 төгрөг \* 3 салбар

3-р байр: Өргөмжлөл, 300'000 төгрөг \* 3 салбар

СЭЗИС-ийн оюутны эрдэм шинжилгээний XIV бага хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон нийт оролцогчдод “БАТЛАМЖ” гардуулан, эрдэм шинжилгээний хурлын эмхтгэлийг сургуулийн цахим хуудсанд байршуулж, олон нийтийн хүртээл болгоно.